

**МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ЗҮЙН БАЙРЛАЛ ТҮҮНИЙ
ГЕОПОЛИТИКИЙН ОНЦЛОГ**

Ц.Ганболд доктор, профессор

Б.Гантулга магистрант

Түлхүүр үг: Газар зүйн байршил, эх газар, Монголын эзэнт гүрэн, Евроази, heartland, land bridge, Wikileaks сайт

Товч агуулга: Дэлхийн улс төрийн байдал өөрчлөгдөж Heartland буюу "Зүрхэн газар" нь Монгол улс болж, газар зүйн байрлал улс төр соёл иргэншлийн хувьд ч анхаарал татаж ихээхэн ач холбогдолтой байна.

XX зуунд Монгол улс дэлхийн улс төрийн газрын зургийн хил хязгаарын өөрчлөлтөд нөлөөлсөн юм. Манж болон Оросын эзэнт гүрнүүд унасан. Японы түрэмгийлэл ба ялагдал, "төмөр хөшгийг" татсан ба нээсэн, Зөвлөлт-Хятадын коммунист холбоо задарсан, дараа нь ЗХУ-ын болон барууны үнэт зүйлс идэвхитэй нэвтэрсэн зэрэг нь соёл иргэншлийн болон геополитикийн хувьд идэвхжин, XXI зуунд орсон одоо үед ч гэсэн Монгол нь эртний, дундад зууны болон XX зууны эхэн үед хэд хэдэн удаа давтагдсаны адилаар томоохон хөршүүдийн нөмөр нөөлгөөс гарч байна. 1980, 1990 - ээд оны зааг үеэс эхлэн түүхчид болон олон улсын судлаачдын анхаарлыг түүхэн үйл явцын идэвхитэй бөгөөд бие даасан субъектын хувиар татах болсон бөгөөд Монголын сонголтоос олон судлаачдын Heartland буюу "дэлхийн зүрх" гэж тодорхойлдог бүс нутаг дахь геополитикийн нөхцөл байдал багагүй хэмжээгээр хамаарах юм. 1980 оны сүүлээр коммунист ертөнц задарч, хүйтэн дайны олон улсын систем устан үгүй болж түүх нь л үлдлээ. 1990 оны ардчилсан хувьсгалаар бид гадаад ертөнцтэй нээлттэй болсноор манай орон дэлхийн глобалчлал давалгааны гадна оршиж чадсангүй гадаад дотоод объектив, субъектив шалтгааны үйлчлэлээс болсон юм. Манай орныг дэлхийн улс гүрнүүд хүлээн зөвшөөрч, найрсагаар хандан туслан дэмжиж байна.

Монгол улс хүний эрх, ардчилал, байгаль орчин зэрэг нийгмийн хөгжлийн олон чухал асуудлаар бүсийн болон олон улсын иргэний нийгмийн байгууллагуудын удирдлага, зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэж тодорхой асуудлаар хамтран ажиллаж, дэлхий нийтийн хөгжилд хувь нэмэрээ оруулж байна. Бүсийн болон олон улсын томоохон арга хэмжээг Монгол улсад зохион байгуулах, улмаар ардчиллын үнэт зүйлийг дэлхий нийтэд хөгжүүлэхийн тулд тууштай ажиллаж байна. Жишээ нь: Ардчилал шинээр сэргээн тогтоосон олон улсын V бага хурал¹⁵⁶ болон саяхан Ази-Номхон далайн парламентын 19-р чуулган болсон нь манай улсын нэр хүндэд нөлөө үзүүлж байна.

Еврази бол Ази-Европыг холбосон хуурай газрын асар том тэнхлэгийн нэр томъёо. АНУ-ын дараа орох эдийн засаг, цэрэг стратегийн бүх үзүүлэлт Евразид төвлөрч байна. Евразид дэлхийн хүн амын 75 хувь, дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувь, дэлхийн нийт эрчим хүчний нөөцийн 75 хувь энд буй бөгөөд "барууны", "үнэн алдартны ортодокс", "хятадын", "лалын", "энэтхэгийн" зэрэг соёл иргэншлүүд энэ тэнхлэг дээр зэрэгцэн солбицон оршиж иржээ. Эндээс дэлхийн томоохон шашнууд үүссэн билээ.

Английн эрдэмтэн геополитикийн салбарт ихийг хийсэн анхдагч нь байсан Халфорд Маккиндер 1904 онд дэвшүүлсэн онол нь дэлхийн төвд Евразийн эх газар

¹⁵⁶ Монгол дахь ардчиллын хөгжил: сорилт боломж "Үндэсний бага хурлын эмхтгэл". УБ., 2005. 45-р тал

оршиж, түүний төвд “дэлхийн зүрх” буюу бүх дэлхийг хянах тохиромжтой нутаг Евразийн эх газрын цул цөм Heartland гэж тэрээр томъёолсон байна. Heartland буюу “дэлхийн зүрхэн газар” хэмээх онолын томъёолол нь “төв газар” гэсэн нөхцөл байдлыг илэрхийлдэг бөгөөд Евразийн эх газрын геополитикийн анхны ухагдахууныг гаргасан юм.

Газар зүйн байршил нь тухайн улсын өнгөрсөн, одоо, ирээдүй болон өгсөх, уруудах замыг нь тодорхойлогч суурь хүчин зүйл аргагүй мөн.

Маккиндер 1919 онд хэвлүүлсэн “Ардчилалын туйлын зорилго- /идеалист/ ба бодит байдал” гэдэг номондоо тэнхлэгийн бүсийг Хартленд буюу зүрхэн газар гэж нэрлээд түүндээ дорно зүгт Монгол Түвдийг өрнөдөд Төв ба Зүүн Европыг нэмэн оруулсан байна. Түүний геополитикийн талаарх үзэл бодлыг нэгтгэн авч үзэхэд өөрийнх нь хэлснээр: “Дорнод европыг хэн захирна, тэр нь хартлендэд ноёрхоно. Хэн хартлендийг захирч байна, тэр дэлхийн арлууд дээр ноёрхоно. Хэн дэлхийн арлуудыг захирна, тэр нь дэлхийд ноёрхоно”¹⁵⁷ гэжээ. Дэлхийн дайнууд, Герман дахь хүйтэн дайн, Оросын дайн зэрэг нь бүгд Зүрхэн газар руу чиглэсэн газар нутгийн томоохон алхам байсныг тэрээр онцолсон юм.

Орос Хятад хоёр улсын хооронд “Буфер-зөөлөвч бүс байгаа мэт” Монгол Улсыг тодохойлдог. Монгол улс бол ОХУ-ын жинхэнэ стратегийн холбоотон. Зөвлөлт Орос улсын гадаад хэргийн ардын комиссар “Г. И. Чичерин, В. И. Ленинд 1921 оны 10 сарын 18 нд бичихдээ: Монголд хувьсгалт засаг тогтсоноор “Номхон далайгаас Каспийн тэнгис хүртэл хувьсгалын эсрэг фронт байгуулахаар зэхэж байсан Японы төлөвлөгөөг бүр мөсөн таягдан хаясан. Найрсаг Монголын халхалснаар манай хилийн асар урт зурваст аюул занал хийлгэхгүй болов” гэж бичсэн байжээ”¹⁵⁸. Мөн Зөвлөлтийн удирдагч И. Сталин 1945 оны 2 сарын 11-ны Ялтын бага хурлаар “Гадаад Монголын /БНМАУ/ статус квог хэвээр хадгалах”¹⁵⁹-ыг хүлээн зөвшөөрүүлснээр манай улсын тусгаар тогтосон байдал олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдөх үндэс болсон байна.

Маккиндер бүтээлдээ Орос Германыг тусгаарлахын тулд Дорнод Европт “зөөлөвч-буфер” байгуулах санааг анх гаргасан. 1919 оны Версалийн гэрээнд энэ санаа тохирох үг өгүүлбэрээр бэхжигдсэний дараа Оросын эргэн тойронд нөлөөгүй хүч багатай буфер улсууд байгуулагдсан. Азид Орос улс болон Хятад улсыг тусгаарлах буфер нь Монгол улс болсон юм.

Монгол улсын оршдог Зүүн хойд Азид дэлхийн их гүрнүүдийн 4 нь, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүний 3 нь, дэлхийн том эдийн засагтай орнууд болох БНХАУ Япон болон БНСУ багтдаг. Зүүн хойд Ази нь Зүүн өмнөд Азитай харьцуулах аваас үндсэндээ интеграцчлагдах үйл явц эхлээгүй байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа нь хоёр талын харилцаа голлосон эсвэл гурван орны хооронд өргөн хүрээнд биш тодорхой буюу явцуу ямар нэгэн асуудлыг хамарсан хэлбэртэй явагдаж иржээ. Тодорхой механизм тогтоогүй байна¹⁶⁰.

Монгол орон бол өрнө дорны уулзвар, Төв Азийн газрын гадаргуу, усны хагалбар, торгоны замын бэлчир, далай тэнгисээс алс хол, Ази тивийн өндөрлөг хэсэгт оршдогоос байгаль, газар зүйн өвөрмөц онцлогтой, эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дөрвөн улирал ээлжлэн солигддог.

¹⁵⁷ М.Баянтер. Геополитик. УБ., 2000. 14-р хуудас

¹⁵⁸ Ц.Батбаяр. “Монгол ба их гүрнүүдийн ХХ зууны эхний хагаст”. УБ., 2006. 72-р хуудас


¹⁵⁹ О.Батсайхан. “Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд (1911-1946)”. УБ., 2005. 282-р хуудас

¹⁶⁰ Д.Баярхүү. Геополитикийн лекцүүд 2007 28-р хуудас

Маккиндерийн авч үзснээр Heartland-ийн ялагдашгүй байдгийн шалтгаан нь тэнгисийн флот энэ бүсэд цөмөрч болдоггүй, харин Евразийн уудам орон зайг эзэлэх тэнгисийн цэргийн оролдлого ямагт сүйрлээр төгсч байв.

Монгол улсын хамгийн өмнө захын цэг нь Орвог гашууны Бор толгой, хойд захын цэг нь Монгол Шарын даваа хүртэл 1259 км. Монгол орны баруун захын цэг нь Алтайн таван богдын Мааньт уул бөгөөд зүүн захын цэг хүртэл Соёлз уулын Модтой хамар хүртэл 2393 км. Монгол орон нь цагийн 6, 7, 8-р бүсүүдэд орших нөхцөлийг бүрдүүлдэг. 1564,4 мян км кв нутаг дэвсгэртэй¹⁶¹, Монгол орон хойд талаараа ОХУ- тай 3485 км өмнө талаараа БНХАУ- тай 4673 км шууд хиллэж “Казакстанаас 55 км- ээр¹⁶²” алслагдсан байдаг. Монгол улс олон улсын төмөр замын болон агаарын тээврийн тэнхлэгт оршиж олон улсын хөдөлмөрийн хуваарьт татагдан орж байна.

Газар зүйн байрлалын хувьд Азийг Европ, Зүүн өмнөд болон Төв Азийг холбож өгсөн “эх газрын гүүр” буюу Land bridge эх газруудыг холбосон гүүрийн үүргийг гүйцэтгэх боломжтой үүнээсээ цаашлаад Heartland болох боломжтой юм. Доорх зургаас Монголын хувьд газар зүйн байршилын ач холбогдол гарч ирнэ.



Монгол улс соёл иргэншлийн хувьд гурван том соёл иргэншлийн дунд байгаагаараа их онцлогтой юм. Хойд талаараа Христийн ортодокс- Үнэн алдартны шашин бүхий Орос улстай, өмнүүрээ Күнзийн суртал бүхий Хятад улстай, баруун талаараа Лалын шашин бүхий дундад Азийн орнуудтай тэр дундаа Казакстантай хил залгаа оршдог бөгөөд исламын шашинт нэг аймагтайн хувьд ингэж үзэж болох юм.

Иргэншлийн хувьд ерөнхийдөө Хятадын Күнзийн үзэл суртал давамгайлсан шинжтэй байна. Ази тивд Япон, Хятад, Буддын, Христийн, Ортодокс гээд хэдэн том соёл иргэншлүүд зэрэгцэн оршдог бол цэрэг стратегийн хүчин чадлын хувьд Япон, Тайвань болон БНСУ зэрэг орнуудад АНУ, ОХУ, БНХАУ, Хойд Солонгос оршиж байна.

¹⁶¹ К.Дэмбэрэл. “Төв Азийн геополитик ба Монгол улс”. УБ., 2005. 23-р хуудас

¹⁶² К.Дэмбэрэл. “Төв Азийн геополитик ба Монгол улс”. УБ., 2005. 17-р хуудас

Одоо Heartland хаана байна?

Дээрх асуултын хариу 1990-ээд оноос эхлэн геополитикчдын анхааралд байгаа асуудал юм. XXI зууны эхэнд 2001 оны 09 сарын 11- ээс хойш бүхэлдээ дэлхийн геополитикт хувьсал гарч АНУ-д болсон террорист халдлагаас эхлэн Арабын ертөнц дэлхий нийтэд аюул занал учруулж эхэлсэн. Сүүлийн 10 гаруй жил дэлхий ертөнцөд олон зүйлд өөрчлөлт гарсан нь нэг талаар улс төрийн хувьд болон геополитикт ч таамаглахын аргагүй зүйлийг ирээдүйд бидэнд харуулах нь дамжиггүй юм.

1991 оны сүүлчээр дэлхийн хамгийн том нутаг дэвсгэр бүхий ЗХУ задарсан нь Евразийн төвд дэх зүрхэн газар арилан “хар цоорхой” бий болсон юм. Ингэснээр дэлхийн газрын зураг дээрээс геополитикийнх нь “зүрхийг” алга болгосон мэт болсон билээ¹⁶³ хэмээн профессор З. Бжезинский тэмдэглэсэн байна.

1990 оны 11 сарын 19 Б.Ельцин Киевт үг хэлэхдээ - бусад ард түмнийг захирч буй ард түмэн аз жаргалтай болж чаддаггүйг түүх бидэнд сургаж өглөө¹⁶⁴. ЗХУ-ын сүйрэл богинохон хугацаанд Чингисийн эзэнт улсын нутаг дэвсгэртэй дүйцэхүйц, зарим газраараа түүнээс ч давж гарсан асар уудам нутаг дэвсгэрийг эзэлсэн Зөвлөлт- Хятадын хүчирхэг коммунист эвслийн аажим задралын төгсгөлийн шат болов.

“Өнгөрсөн хоёр мянган жилд анх Төв Ази ялгарч тэр нь “Heartland”- ийн түүхэн нутаг-муж болсон. Эндээс Хүннү, Түрэг, XIII зуунд Монголчууд соёлт ард түмнүүдийн суудаг дэлхийн хэсэг Ази, Европт өөрийн нөлөөгөө тогтоосон.

Евразийн байгалийн тавьсан түүхэн зорилтыг анх удаа, Евразийн талын бүх нүүдэлчин аймгуудыг захирсан Монголын эзэнт гүрний үед Евразийн соёлын ертөнц анх нэгдмэл болсон. Хатуу цэргийн зохион байгуулалттай хүчирхэг төр улсыг байгуулсан. Монголын эзэнт гүрний засаглал нь үндсэндээ цэргийн ноёрхолд түшиглэж байв. Хүчээ маш хурдан шилжүүлэн байршуулах, шаардлагатай үед нэгтгэн төвлөрүүлэх гайхамшигт боломжийг агуулсан хатуу дэгтэй тактикийг хэрэглэсний ачаар бүрдсэн Монголын ноёрхолыг эдийн засгийн буюу санхүүгийн зохион байгуулалттай тогтолцоо дагаж гарч ирээгүйгээс гадна монголчуудын эрх мэдэл соёлоор давамгайлах үзэл сэтгэлд тулгуурлаагүй юм. Х. Макиндерийн дүгнэлт: “гадаад варваруудын шахалтын ачаар Европ өөрийн соёл иргэншлийг байгуулж чадсан” гээд цааш нь: “Европ ба Европын түүх бол ... Ази ба Азийн түүхэнд захирагдсан үзэгдэл” гэжээ. Монголчуудын байлдан дагуулалын дараа Орос нь Монгол гүрний геополитикийн хүрээнд бүрэн багтсан. Иймд Евразичууд геополитикийн талд Византийн тухай биш, харин “Азийг нэгтгэгч Чингис ба Төмөрийн үйл хэргийг үргэлжлүүлэгч Их Хаадыг залгамжлагч нь Орос”¹⁶⁵ гэсэн Монголын өвийн тухай дүгнэлтэнд хүрсэн байдаг.

XX зуунд тэрээр Heartland- г ЗХУ гэж харсан. Евразичлалын үндэслэгч П. Н. Савицкий “Оросын аз жаргал татарт оногдоно, өөр хэнд ч биш”¹⁶⁶ гэж үзсэн. Евразичууд “татаржилтгүйгээр Орос байхгүй байсан” гэдгийг зөвшөөрдөг. Монголын байлдан дагууллаар Орос Евразийн үйл явцын ерөнхий замд татагдан орсон. Оросыг багтаасан Монголчуудын “Алтан ордны” улс нь Орос улсын нэгдэлтэй байдлыг хангаж өгөөд зогсоогүй зүрхэн газар болгох эхлэлийг тавьсан. ЗХУ Евразийн уудам орон зайг хамарсан газар нутагтай, эдийн засаг, хүн ам, аж

¹⁶³ З.Бжежинский. “Шатрын аварга хөлөг”. 2003. 91-р хуудас

¹⁶⁴ З.Бжежинский. “Шатрын аврага хөлөг”. 2003. 103-р хуудас

¹⁶⁵ Н.А.Нартов. “Геополитик”. УБ., 2003. 88-р хуудас

¹⁶⁶ Н.А.Нартов. “Геополитик”. УБ., 2003. 87-р хуудас

үйлдвэр, цэрэг стратегийн болон зам харилцаа олон улсад нөлөөлөх улс төрийн бодлогыг явуулан байгалийн баялагаараа ч хүчирхэг гүрэн болж улс төрийн системийн хувьд гадагшаа тэлэх алхамыг бүрдүүлж байсан юм. Олон ард түмнийг социалист хөдөлгөөнд нэгтгэж дэлхийг хоёр туйлт болгон социализмаар дамжуулан буурай хөгжилтэй болон дайнд ялагдсан улсуудыг нэгтгэсэн асар том цэрэг болон улс төрийн үйл ажиллагаа явуулж байсан нь үнэхээр гайхамшигтай. Геополитикийн хувьд ч аваад үзсэн Heartland- г бий болгож чадсан юм.

Улс төрийн системийн хувьд нэгдэлтэй нягт байна гэдэг маань гадагшаагаа тэлдэг, харин улс төрийн системийн хувьд хүч султай байх юм бол хумигдан эзлэгдэнэ. Дээрх хоёр эзэнт гүрний тулгуур нь нэгдэл байсан юм. Евразийн улсуудад улс төрийн засаглал захиргаадалтын шинжтэй байв.¹⁶⁷

Евразийн тэнхлэг дээр хэн ноёрхоно тэр дэлхийг удирдана гэсэн Макиндерийн онол үүгээрээ батлагддаг. Heartland-ын давуу тал нь эх газарт газар нутгаа тэлэх боломжийг олгодог. Харин далайгаар хязгаарлагддаг улс орнуудын хувьд тэлэх боломж нь хязгаарлагддаг байна.

Хятад орон сүүлийн жилүүдэд эдийн засгийн эрчимтэй өсөлт болон техник технологийн болон цэрэг стратеги, хүн ам, улс төрийн хувьд дэлхийн гүрний хэмжээнд хүртэл өргөжин тэлэх хандлагатай болоод байна. Хятад улс, дэлхий ертөнц улам эрчтэй хөгжиж байгаа тэр дундаа либераль ардчилал дэлхийд тархаад байгаа өнөө цагт энэ систем хэр удаан тогтох бол. Саяхан Арабын улсуудад гарсан Туннисийн ерөнхийлөгч Бен Али-гийн дарангуйлал төгсгөл болж Арабын бусад оронд цуурайтаж эсэргүүцлийн үндэс суурийг тавьсан юм. Египтийн ерөнхийлөгч Хосни Мубаракийн дэглэм, Ливийн удирдагч Муаммар Каддафигийн дарангуйлал унасан. Марроккогийн улсад 350 жил ноёрхсон Мохеммед IV хааны Алутын хааны хязгааргүй эрхийг хязгаарлах, Йемен улсын ерөнхийлөгч Али Абдалла Салехийг огцрохыг шаардсан гэх мэт үйл явдалууд Арабын ертөнцийг нойрноос нь сэрээж ардчилал эрх чөлөө, шудрага ёсны төлөөх ард түмний тэмцэл Туннисаас эхлэн Египет, Иран, Алжир, Ливи, Маррокко, Бахрейн зэрэг орнуудад өрнөсөн юм. Эдгээр үйл явдал нь Хятад улсад нөлөөлж болзошгүй аюулын нэг болж байгаа билээ. Шашин шүтлэг, ёс заншлаар нь Шинжааны өөртөө засах оронд болон түүгээр дамжуулан Түвд, Өвөр Монголын өөртөө засах оронд тусгаар тогтнолын хөдөлгөөн өрнөж болзошгүй.

Дээрх тэмцэл хөдөлгөөнүүд болж буй улс орнууд нь бүгд лалын шашинт оронд болж байгаагаараа онцлог, бүхэл бүтэн залуу үеийнхэн босч байна. Орчин үеийн шинэ техник технологи эдгээр хөдөлгөөнийг зоригжуулж өдөөж нийгэм, ард иргэд Авторитар дэглэмийг няцааж, эдгээр хөдөлгөөнд Пан Арабын шинж тэмдэг байгаа ч өмнө нь ноёрхож ирсэн үзэл суртал, ардчилсан бус хэлбэрийг эсэргүүцсэн жагсаал болж байгаа юм. Улс төр судлаачид энэхүү хувьсгалыг лидергүй хувьсгал гэсэн нь интернэтийн хүч мэдээллийн технологийн хурдац юм. Энэхүү байдал нь Хятадын коммунист дэглэм болон өнөөдрийн хаалттай хэмээн удаан хугацаанд оршиж ирсэн Хойд Сологосын дэглэмүүд зэрэг "хүйтэн дайнаас" үүдэлтэй түгшүүрийн голомтуудад нөлөө үзүүлж болох юм.

WikiLeaks сайтын үндэслэгч Жулиан Ассанж АНУ-ын нууц материалуудыг нийтэлсэн нь ч үүнд томоохон нөлөө үзүүлсэн юм.

Манай улсын газар зүйн байрлал тааламжтай боловч улс орны хөгжил удаан, зам харилцаа муу, үйлдвэрлэл тааруу байгаа ч ашигт малтмал дээр тулгуурлан техник тенологийн дэвшилийн хурд Ази тив дээрх улс төр эдийн засгийн хүрээллээрээ дамжуулан хөгжих таатай боломж байгаа юм. Хүчний тэнцвэр

¹⁶⁷ Н.А.Нартов. "Геополитик". УБ., 2003. 86-р хуудас

өнөөдөр Ази тив дээр өрнөж байгаа нь энэ боломжийг нээж өгөх юм. Бид орчин үеийн технологийг авах болон түүнийг өөрийн нийгмээ батжуулах зорилгоор ашиглах боломж илүү их байна. Үүний жишээ нь Япон, Сингапур, Тайван, Саудын Араб болон Иран зэрэг орнууд орчин үеийн хүчирхэг нийгмийг бий болгож, тэр хэрээрээ өөрийн гэсэн геополитикийг явуулж чадсан. Эдгээр орнуудын туршлагаас суралцан хөгжиж болох юм.

Геополитик нь хүчирхэг гүрнүүд ямарваа нэгэн газар нутагт өөрийн улс төрийн хүчээ тогтоохыг хэлдэг. Тэр газар нь стратегийн их нөөц эсхүл ашигтай байрлал газар зүй, улс төр хоёрын нэгдсэн ойлголт бөгөөд өргөн хүрээтэй улс төрийн бодлогуудыг хамруулдаг. /мужийн түвшинээс эхлээд улсын түвшинд хүртэл жагсаах байдлаар/. Геополитик дэлхийг өөрчлөх бодит хэрэгсэл болдог төдийгүй, бүхнээс илүү тэргүүлэх улс орон ба эх газрын бодлогыг урьдчилан мэдээлэх түлхүүр болж байдаг. Нэг ёсондоо ирээдүй рүү чиглэсэн шинжлэх ухаан юм.

Монгол улсын засгийн газраас “Мянганы зам” төсөл, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” зэрэг бодлогын баримт бичгүүдийг гарган хэрэгжүүл эхэлж байна. Зүүнээс баруун, хойноос урагш огтолцсон авто замуудыг тавьж байна. Төмөр замын хувьд хойноос өмнө босоо чиглэлийн ганц шугамтай байгаа ч дотоодын хөндлөн зам тавих асуудлыг УИХ-аар батлуулсан байна. Уул уурхай хөрөнгө оруулалтыг даган дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзвэл тээвэрлэлтийн асуудал давхар шийдэгдэнэ.

Гадны улс орнуудын ашиг сонирхолуудын огтолцол манай улсад байгаа учраас бид тэндээсээ хожих боломжтой юм.

Монгол улсын тухайд бүс нутаг дахь нөлөө бүхий улс гүрнүүдийн ашиг сонирхолын ойртолт, зөрчил, хүчний тэнцвэрийг мэдэрч улмаар гадаад улс төр, эдийн засаг үйл ажиллагаагаа харгалзан үзэх ухаалаг дипломат ажиллагаа явуулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.¹⁶⁸

Монгол улсын гадаад харилцаа нээлттэй болж, ислам шашин дэлгэрсэн, исламын олон оронтой эдийн засаг, улс төр, соёл хүмүүнлэгийн талаар харилцаа хамтран харилцан хамтран ажиллаж байна. Үүний дагуу тэдгээр орны эдийн засаг, нийгэм, улс төрийн байгуулалт, түүх, соёл, шашин шүтлэгийг судлах, зохих мэдээллийн мэдлэгтэй байх тэдгээрийн улс төр гадаад бодлогодоо тусгаж ажиллах шаардлага гарч байгаа юм.¹⁶⁹

ОРОС



¹⁶⁸ Д. Цолмон. “Зүүн Хойд Азийн төлөв байдал ба Монгол улс”. УБ., 2003. 84-р хуудас

¹⁶⁹ К. Дэмбэрэл. “Төв Азийн геополитик ба Монгол улс”. УБ., 2005. 176-р хуудас

Манай орны эргэн тойронд угсаа гарал нэгтэй олон улс орнууд нэгэн үе Монголын нэг хэсэг байсан юм. Гэхдээ ирээдүйд шашин шүтлэг, соёл иргэншил, түүхийн хувьд ойр дөт байдлаар нэгдэн нягтарч болох юм. Монгол улс эргэн тойроны автономит буфер улсуудаар хүрээлэгдсэн байгаа нь дээрх зурагнаас харвал илүү тодорхой харагдаж болох юм. Түвд улсыг бидэнд хамаатуулан үзэх явдал сүүлийн жилүүдэд ихээхэн газар аваад байгаа ч шашин шүтлэгийн хувьд ойролцоо гэж үздэгээр нь тайлбарладаг. Оросын геополитикч А. Дугин Түвд, Монголын холбооны улсын тухай гарган тавьсан байдагт гайхах зүйлгүй юм. Тэрээр Түвд-Шинжаан-Монгол-Манжуур Орос улсын алс Дорнод дахь өөрийн хилийн аюулгүй байдлын бүс гэж үздэг.

Дүгнэлт

Иймд Монголын эзэнт гүрэн 200 орчим жил евразийг эзэгнэн оршин тогносон Heartland болон ноёрхож байсан нь дэлхийн түүхэн асар их хувь нэмэр оруулсан ба Өрнө Дорны соёлыг нэвтрүүлж Их торгоны замыг хяналтандаа авч соёл иргэншлүүдэд үлэмж нөлөө үзүүлж Ази Европыг холбосон хуурай замыг нээсэн нь дэлхийн хөгжлийн нэгэн үеийг тодорхойлж өгсөн нь түүхэн үнэн билээ. Монгол улс газар зүйн хувьд ч Евразийн төвд байгаа нь дээрх онолыг батлах боломж байгаа ч өнөөдөр газар нутагийн хэмжээ нэг хүн амд ноогдож байгаа, байгалийн баялаг зэргээрээ дэлхийн нийтийн анхааралын төвд орсон нь XXI зуунд монгол орон дэлхийн зүрхэн газар болох үндэслэл ихтэй.

Өнөөдөр Heartland-г бүхэл бүтэн дэлхий ертөнцийг эзлэн түрэмгийлэх утгаар ойлгох нь хэцүү ээдрээтэй харин газарзүйн байрлал, хэр зэрэг олон улстай хамтын ажиллагаагаа өргөжүүлж тэр дундаа голлох байр суурь эзэлж байгаагаар авч үзвэл илүү зохимжтой юм.

Геополитикийн тоглоомын дүрмээр бол Монгол улс нь шатрын хүү гэхдээ шатрын хүүд ухрах зам байхгүй зөвхөн урагшаа нүүх л сонголт байдаг ба хүү ноён унагаадаг гэдгийг тоглоом өөрөө харуулдаг. Өнгөрсөн түүхээ судалж түүнд байгаа сайн сайхан бүхнийг магтан өргөмжлөх нь зүй боловч бид ямагт урагшаа харж урагшлан алхах ёстой. Тэсч үлдэх алхам нь бидний нүүх нүүдэл маань бидэнд харуулна. Бид хоцрох юм бол аль нэг улсын хараат байдалд орох үндэслэл ихтэй юм.

Орчин үеийн олон геополитикчид “улсын хүч бол систем дахь хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийн цогцолбор үзүүлэлт” гэж үздэг. Газар зүйн байрлал нь улсыг хүчирхэг болоход таатай байх төдийгүй түүнд дайсагнаж болох талын эсрэг дайсагнасан үйл ажиллагаанд сайн бааз суурь болох төв байр суурь зэрэг стратегийн давуу талыг өгдөг. Хантигтоны тэмдэглэснээр өнөөдөр шашин шүтлэг, соёл иргэншил, түүхийн хувьд нэгдэн нягтрах юм бол эргэн тойрон үндэстнүүдээ нэгтгэсэн гүрэн болж болох юм.

Abstract

Academically, the study of geopolitics involves the analysis of geography, history and social science with reference to spatial politics and patterns at various scales (ranging from the level of the state to international).

Sir Halford Mackinder's Heartland concept showing the situation of the "pivot area" established in the Theory of the Heartland.

Ашигласан ном

1. К.Дэмбэрэл. "Төв Азийн геополитик ба Монгол Улс". УБ., 2005
2. Д.Цолмон. "Зүүн хойд Азийн төлөв байдал ба Монгол Улс". УБ., 2003
3. Д.Баярхүү. "Евразийн геополитик олон улсын харилцаа өнгөрсөн, одоо, ирээдүй". УБ., 2005
4. Н.А.Нартов. "Геополитик". УБ., 2003
5. Д.Баярхүү. "Геополитикийн лекцүүд". УБ., 2007
6. З.Бзенжинский. "Шатрын аврага хөлөг". УБ., 2003
7. Монгол дахь ардчилалын хөгжил: сорилт боломж "Үндэсний бага хурлын эмхтгэл". УБ., 2005
8. Р.Даль. "Ардчиллын тухай". орч. Д. Ганхуяг. УБ., 2004.
9. Ц.Батбаяр. "Монгол ба их гүрнүүд ХХ зууны эхний хагаст". УБ., 2006
10. Самуэль.П. Хантигтон. "Иргэншил хоорондын мөргөлдөөн ба шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам". УБ., 2005.
11. "Улс төрийн шинжлэх ухаан". МУИС НШУС. УБ., 2010.
12. А.Ж.Тойнби. "Түүх судлал". УБ., 2007
13. М.Баянтер. В.Батцэнгэл. "Геополитик". УБ., 2000.
14. Ц.Батбаяр. "Монгол ба их гүрнүүдийн ХХ зууны эхний хагаст". УБ., 2006.
15. О.Батсайхан. "Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд (1911-1946)". УБ., 2005.
16. "Өдрийн сонин"
17. www.olloo.mn
18. www.google.com